

Засгийн газрын 2018 оны 382 дугаар

тогтоолын 6 дугаар хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД ОРОН НУТАГТ

АЖИЛЛАСНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

(Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор гарчигт нэмэлт орсон бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг орон нутагт жигд чанартай хүргэх зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна. (Энэ заалтыг Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

2. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг дараахь албан тушаал эрхэлж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно: (Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

		Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
	Аймгийн нэгдсэн эмнэлэг/бүсийн оношилгоо, эмчилгээний төв, эрүүл мэндийн бусад байгууллагын:	
	Сум (сум дунд), тосгоны эрүүл мэндийн төвийн:	
	Сум (сум дунд), тосгоны эрүүл мэндийн төвийн:	

3. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг дараахь албан тушаал эрхэлж байгаа сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага, соёл, урлагийн болон биеийн тамир, спортын байгууллага, байгаль орчин, ус, цаг уур, орчны шинжилгээний байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно: (Энэ заалтад Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Мөн Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2024-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

		Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь	
		Аймгийн төвийн суманд	Хөдөөгийн суманд

1.	<p>1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын менежер</p> <p>2. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын менежер</p> <p>3. Боловсролын сургалтын байгууллагын арга зүйн мэргэжилтэн (Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор хассан)</p> <p>4. Нийгмийн ажилтан</p> <p>5. Театр, чуулга, Соёлын ордон, соёлын төвийн дарга (Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)</p> <p>6. Музейн захирал</p> <p>7. Нийтийн номын сангийн захирал</p> <p>8. Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны дарга, нэгжийн дарга (Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)</p> <p>9. Биеийн тамир, спортын төсвийн байгууллагын нэгжийн дарга (Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)</p> <p>10. Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер (Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)</p>		
----	---	--	--

2.	<p>1. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн багш</p> <p>2. Бага боловсрол олгох багш</p> <p>3. Тусгай хэрэгцээт боловсролын багш</p> <p>4. Номын санч</p> <p>5. Дотуур байрны багш</p> <p>6. Сургуулийн өмнөх боловсрол олгох багш</p> <p>7. Туслах багш</p> <p>8. Соёлын ордон, соёлын төвийн багш, соёлын өвийн ажилтан, орон нутаг судлах танхимын ажилтан, номын санч, зохион байгуулагч, соёлын өвийн бүртгэл мэдээллийн санч (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p> <p>9. Кино техникийн ажилтан</p> <p>10. Музейн тайлбарлагч</p> <p>11. Боловсролын сургалтын байгууллагын арга зүйн мэргэжилтэн</p> <p>12. Музей, номын сангийн арга зүйч, сан хөмрөгч</p> <p>13. Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүртгэл мэдээллийн санч, судалгаа, сурталчилгаа хариуцсан ажилтан (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p> <p>14. Соёл, урлагийн бусад уран бүтээлч, соёлын ажилтан (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p> <p>15. Биеийн тамир, спортын ахлах арга зүйч, ахлах дасгалжуулагч (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p> <p>16. Биеийн тамир, спортын арга зүйч, дасгалжуулагч, мэргэжилтэн (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p> <p>17. Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны туслах байгаль хамгаалагч (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p> <p>18. Цаг уурын ертөөний техникч, хөдөө аж ахуй, усны харуулын ажиглагч, газогенераторчин (<i>Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2024-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө</i>)</p>		
----	---	--	--

**4. Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно. (Энэ заалтыг Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)**

5. Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчид 80 хүртэл хувиар нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Мөн энэ заалтад Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2023-7-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

6. Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно. (Энэ заалтын дугаарлалтыг Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор өөрчилсөн)

-----o0o-----